



## МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7,18 дугаар зүйлийн 18.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын өрөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуянд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН



0023100222

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны  
05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга:      Онцгой байдлын өрөнхий газрын  
                  Гал түймэртэй тэмцэх газрын дарга

Гишүүд:      Онцгой байдлын өрөнхий газрын  
                  Урьдчилан сэргийлэх газрын дарга

Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга

Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Аюулгүй байдал үнэлгээний нэгдсэн төвийн дарга

Захиргааны удирдлагын газрын Тасгийн дарга хуулийн зөвлөх

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэлтсийн дарга

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч

Техникийн шинжлэх ухааны эрдмийн зэрэгтэй Онцгой байдлын байгууллагын алба хаагч

Мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл 2 иргэн

Нарийн бичгийн дарга:

Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны  
26 дугаар сарын 30-ны өдрийн 39 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

## ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөл ( цаашид “ зөвлөл” гэх) Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 7 дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.8, 18.9, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийх, Галын аюултай бүтээгдэхүүн, гол түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах, Гал түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тус тус сонгон шалгаруулж гэрээ байгуулах, гол түймрийн аюулын үнэлгээг хянаж зөвлөмж, дүгнэлт гаргах ажлыг эрхлэх мэргэжлийн орон тооны бус бүтэц мөн.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль бусад хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийг мөрдөж ажиллана.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн дарга нь Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга байна.

2.3. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангуулах, зохион байгуулах, гишүүдээс санал хураах, гарсан шийдвэрийг баримтжуулах, шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлэх, бүртгэл хөтөлж мэдээллийн сан үүсгэх ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна. Нарийн бичгийн дарга нь санал өгөх эрхгүй байна.

2.4. Зөвлөлийн гишүүдийн 60 хувь нь галын аюулгүй байдлын инженер, техникич мэргэжилтэй, 20 хувь нь техникийн шинжлэх ухааны эрдмийн цол зэрэгтэй, 20 хувь нь эрх зүйч мэргэжилтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус байгууллага, бэлтгэл офицер албан хаагчдаас тус бүр нэг хүнийг гишүүнээр оруулж болно.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Барилга байгууламж, үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагааны зураг төсөл нь галын аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд магадлал хийх иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулахад зөвлөмжөөр хангах;

3.1.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасан гал түймрийн аюулын үнэлгээний тайланг хянаж зөвлөмж гаргах;

3.1.3. Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, байгууллагад зөвлөмж гаргах, бүртгэх;

3.1.4. Барилга байгууламжийг гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд үйл ажиллагаатай нь холбогдуулан дүгнэлт гаргах, бүртгэх;

3.1.5. Барилгын зураг төсөл боловсруулах болон барилгын гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн угсралт гүйцэтгэдэг аж ахуйн нэгж байгууллага нь галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм нормативыг удаа дараа зөрчсөн тохиолдолд үйл ажиллагаа нь шаардлага хангахгүй талаар санал дүгнэлт гаргаж, тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

3.1.6. Галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм норматив, техникийн дүгнэлт, инженерийн тооцоо судалгаа, шийдлийг хэлэлцэж зөвлөмж гаргах;

3.1.5 Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах иргэн, аж ахуйн нэгжид дүгнэлт гаргах, бүртгэх;

#### Дөрөв. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах

4.1 Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийн эхийг нэг хувь, танилцуулга бусад материалыг гишүүдийн тоогоор хувилан бэлтгэж, зөвлөлийн хуралдаан хуралдахаас 7 хоногийн өмнө зөвлөлийн нарийн бичгийн даргад бичгээр болон цахим файл хэлбэрээр ирүүлсэн байна.

4.2 Нарийн бичгийн дарга зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийг зөвлөлийн даргад танилцуулах ба түүний зөвшөөрлийг үндэслэн хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, гишүүдэд 5 хоногийн өмнө цахим файл хэлбэрээр явуулна.

4.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.1 Танилцуулга бэлтгэж тухайн асуудлыг хэлэлцүүлэх болсон үндэслэл, шаардлага, үүсэж болох үр дагаврууд, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, ач холбогдол, үр дүнг оновчтой тодорхойлсон байна;

4.3.2 Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг мэргэжлийн мэргэшсэн болон зөвлөх инженерийн санал шүүмжийг бичгээр гаргуулан авч хавсаргасан байх;

4.4 Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалтай урьдчилан сайтар танилцсан байна.

Тав. Зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэр

5.1. Зөвлөл нь гал түймэртэй тэмцэх чиглэлээр дүгнэлт гаргах, шийдвэр гаргахад зөвлөмж гаргах, үйл ажиллагаа явуулах эрх хүссэн хүсэлт зэргээс хамаарч улиралд 1 удаа, хүсэлт ирүүлсэн тухай бүрд хуралдана. Хуралдаан 75 буюу түүнээс дээш хувийн гишүүдийн иртэй байна.

5.2. Зөвлөлийн дарга хуралдаан даргалах боломжгүй үед түр томилогдсон зөвлөлийн гишүүн хуралдааныг удирдан явуулах бөгөөд зөвхөн хуралдааныг даргалж, шийдвэр гаргах эрхгүй байна.

5.3. Хуралдааныг зөвлөлийн дарга, эрх олгогдсон гишүүн удирдан явуулах ба хуралдааны явц, саналыг нарийн бичгийн дарга бичгээр тэмдэглэл хөтөлж баримтжуулна. Нарийн бичгийн дарга оролцох боломжгүй үед зөвлөлийн дарга зөвлөлийн гишүүдээс түр томилж нарийн бичгийн даргаар оролцуулж болно.

5.4. Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудлаар асуулга тавьж хариу тайлбар авах, санал солилцох замаар хэлэлцүүлэг явагдана. Хэлэлцүүлэг дууссаны дараа зөвлөлийн гишүүд санал, шүүмж гаргана.

5.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын онцлогийг харгалзан зөвлөлийн даргын зөвшөөрснөөр, холбогдох албан тушаалтан, төлөөллийг хуралдаанд оролцуулж болно.

5.6. Зөвлөлийн хуралдааны явцыг баримтжуулах зорилгоор албан ёсны тэмдэглэл хөтлөх ба түүнд хуралдаанд оролцсон гишүүд, тухайн асуудал бүр дээр тэдгээрийн гаргасан санал, шүүмжлэл, шийдвэр түүнчлэн шаардлагатай гэж үзвэл санал хураалтын дүнг заавал тусгаж, түүнийг Зөвлөлийн даргад танилцуулж баталгаажуулна.

5.7. Саналыг илээр хураах ба шийдвэр гаргах бүрд оролцсон гишүүдийн 50-с дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.

5.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдаанаас гарсан дүгнэлт, шийдвэр, зөвлөмжийг /тухай бүрт нь ажлын 3 өдрийн дотор албан бичгээр/ хүргүүлэх, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах, хэлэлцсэн материал, баримт бичгийг цэгцлэн архивын нэгж бүрдүүлэн зохих журмын дагуу шилжүүлэх үргийг хүлээнэ.

5.9. Зөвлөл нь шийдвэрийг баталгаажуулах, албан бичиг хүргүүлэх, Зөвлөлийн дүгнэлт гаргахдаа Онцгой байдлын ерөнхий газрын хэвлэмэл хуудас, тамгыг ашиглана.

5.10. Гэрээ байгуулахдаа Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд Гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчтай байгуулна.

5.11. Зөвлөл нь холбогдох хууль, дүрэм, журам зөрчиж дүгнэлт, шийдвэр гаргасан гэж үзвэл Зөвлөлийн дарга асуудлыг өөр бүрэлдэхүүнээр шалгуулж, Зөвлөлийн хуралдааныг 5-аас цөөнгүй гишүүнтэйгээр дахин нэг удаа хуралдуулж асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

5.12.Хурлаас чөлөө авсан гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж, өөрийн саналаа бичгээр гаргаж нарийн бичгийн даргад урьдчилан ирүүлсэн бол зөвлөлийн хуралд санал өгснөөр тооцно.

5.13. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжлэг аваагүй асуудлыг холбогдох баримт бичиг материалын хамт буцаана.

## Зургаа. Хориглох зүйл

- 6.1. Ирц хүрээгүй зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж шийдвэр гаргах.
- 6.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн шийдвэр гаргах.
- 6.3. Дүгнэлт гаргуулахаар, эрх хүссэн хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөл санал хураах үед хуралдааны танхимд байх.

---о0о---